

## ТАНИЛЦУУЛГА

“Журам батлах тухай” Засгийн газрын  
тогтоолын төслийн тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацааны шимтгэл төлөх журмыг Засгийн газар тогтооно” гэж, Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт “Энэ зүйлийн 9 дэх хэсэгт заасан нийгмийн даатгалын шимтгэлийг тооцох орлогын хэмжээ, шимтгэл төлөх журмыг Засгийн газар батална” гэж тус тус заасан.

Дээрх хуулийн хэрэгжилтийг зохицуулах зорилгоор Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 60 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацааны нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам”-ыг баталж мөрдөн ажиллаж байна.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг баталсан бөгөөд хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт “Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан Засгийн газар батална” гэж заасан.

Хуулийн энэ заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Журам батлах тухай” Засгийн газрын тогтоол, журмын төслийг боловсрууллаа.

Энэхүү тогтоолын төсөлд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс санал авсан. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 81 дүгээр тоот албан бичгээр уг тогтоолын төслийг зарчмын хувьд дэмжсэн тухай санал ирүүлсэн болно.

Энэхүү Засгийн газрын тогтоол батлагдсанаар улсын болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс нэмэлт хөрөнгө шаардагдахгүй болно.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ